

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: [huanganm@audit.gov.mn](mailto:huanganm@audit.gov.mn)  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)  
“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)  
Аудитор: Н.Энхтуяа  
Утас: 99075818 Цахим хаяг: [asaudit.mn@gmail.com](mailto:asaudit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж .....	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ  
Х.ХАЙНАР ТАНАА

АДБЗ. Дд. Н № 99  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сургуулийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

#### Аудитын гол асуудал

Материаллаг буруу эрсдлийн үнэлгээ өндөр, анхаарах татах асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>61,401,192.44</u></b>	<b><u>56,497,205.05</u></b>
33	АВЛАГА	-	819,812.61
335	Бусад авлага	-	819,812.61
3351	Байгууллагаас авах авлага	-	819,812.61
35	БАРАА МАТЕРИАЛ	61,401,192.44	55,677,392.44
354	Хангамжийн материал	61,401,192.44	55,677,392.44
35410	Бичиг хэргийн материал	1,268,400.00	240,000.00
35420	Аж ахуйн материал	4,631,763.44	4,615,163.44
35470	Бусад хангамжийн материал	54,186,929.00	50,822,229.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,031,651,131.02</u></b>	<b><u>1,983,594,336.24</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,031,651,131.02	1,983,594,336.24
392	Биет хөрөнгө	1,961,479,131.02	1,895,077,336.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,092,440,533.00	2,092,440,533.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(186,539,929.96)	(248,597,673.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,400,000.00	58,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(33,666,666.73)	(39,266,666.77)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	81,450,400.00	87,500,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(60,345,241.07)	(66,193,903.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	41,355,500.00	45,855,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,738,860.16)	(37,107,500.56)
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,908,400.00	33,908,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30,785,004.06)	(31,861,752.90)
393	Биет бус хөрөнгө	70,172,000.00	88,517,000.00
39301	Програм хангамж	2,050,000.00	2,050,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	68,172,000.00	86,817,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(50,000.00)	(350,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,093,052,323.46</u></b>	<b><u>2,040,091,541.29</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>55,636,322.65</u></b>	<b><u>59,392,622.65</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	55,636,322.65	59,392,622.65
413	Өглөг	55,636,322.65	59,392,622.65
4136	Бусад өглөг	55,636,322.65	59,392,622.65
41361	Байгууллагад төлөх өглөг	55,636,322.65	59,392,622.65
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,037,416,000.81</u></b>	<b><u>1,980,698,918.64</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,037,416,000.81	1,980,698,918.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,266,577,802.00	2,285,222,802.00
51101	Өмч: - төрийн	2,266,577,802.00	2,285,222,802.00
512	Хуримтлагдсан үр дүн	(393,546,367.99)	(468,908,450.16)

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51210	Өмнөх үеийн үр дүн	(300,840,413.99)	(393,546,367.99)
51220	Тайлант үеийн үр дүн	(92,705,954.00)	(75,362,082.17)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	164,384,566.80	164,384,566.80
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,093,052,323.46</u></b>	<b><u>2,040,091,541.29</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>485,474,729.72</b>	<b>769,079,000.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>467,453,100.00</b>	<b>769,079,000.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	244,169,600.00	402,573,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,289,600.00	402,573,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	11,674,000.00	71,205,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	52,506,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,474,000.00	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	17,899,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	211,609,500.00	295,300,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,609,500.00	295,300,300.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>578,180,683.72</b>	<b>844,441,082.17</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>578,180,683.72</b>	<b>844,441,082.17</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	577,680,562.72	834,783,842.17
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,890,166.31	257,592,187.39
210101	Үндсэн цалин	151,965,784.94	185,644,274.39
210102	Нэмэгдэл	27,924,381.37	34,938,025.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	21,560,000.00
210104	Урамшуулал	-	15,449,888.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,289,800.00	32,203,300.00
210201	Тэтгэврийн даатгал	17,092,900.00	22,686,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,799,200.00	2,379,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,439,400.00	1,903,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,800.00	475,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,598,500.00	4,758,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	267,245,701.65	279,052,720.00
210301	Гэрэл, цахилгаан	4,107,803.00	5,836,744.00
210302	Түлш, халаалт	258,934,322.65	266,732,400.00
210303	Цэвэр, бохир ус	4,203,576.00	6,483,576.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,263,400.40	11,052,500.00
210401	Бичиг хэрэг	80,700.00	1,988,900.00

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	2,519,500.40	3,010,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	486,700.00	1,464,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	583,260.00	4,589,300.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	183,400.00	5,250,000.00
210604	Урсгал засвар	-	5,250,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	781,000.00	3,360,000.00
210702	Дотоод албан томилолт	781,000.00	3,360,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,865,039.60	2,713,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,865,039.60	1,430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	474,440.00
210807	Газрын төлбөр	-	163,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	98,162,054.76	243,559,194.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,354,800.00	165,979,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	312,160.00	327,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,495,094.76	77,251,794.78
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	500,121.00	9,657,240.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	1,465,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,465,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	680,360.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	680,360.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	121.00	7,511,880.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,511,880.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(92,705,954.00)</u></b>	<b><u>(75,362,082.17)</u></b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(92,705,954.00)</u></b>	<b><u>(75,362,082.17)</u></b>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>472,693,100.00</u></b>	<b><u>769,079,000.00</u></b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>467,693,100.00</u></b>	<b><u>769,079,000.00</u></b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	231,289,600.00	402,573,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,289,600.00	402,573,700.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	24,794,000.00	71,205,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	52,506,000.00

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,594,000.00	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	17,899,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	211,609,500.00	295,300,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	211,609,500.00	295,300,300.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>458,013,100.00</b>	<b>758,529,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>458,013,100.00</b>	<b>758,529,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>457,512,979.00</b>	<b>748,871,760.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	179,924,800.00	258,412,000.00
210101	Үндсэн цалин	152,000,418.63	186,464,087.00
210102	Нэмэгдэл	27,924,381.37	34,938,025.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		21,560,000.00
210104	Урамшуулал	-	15,449,888.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	24,289,800.00	32,203,300.00
210201	Тэтгэврийн даатгал	17,092,900.00	22,686,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,799,200.00	2,379,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,439,400.00	1,903,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,800.00	475,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,598,500.00	4,758,600.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	211,609,379.00	275,296,420.00
210301	Гэрэл, цахилгаан	4,107,803.00	5,836,744.00
210302	Түлш, халаалт	203,298,000.00	262,976,100.00
210303	Цэвэр, бохир ус	4,203,576.00	6,483,576.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,198,700.00	9,331,800.00
210401	Бичиг хэрэг	864,000.00	1,210,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,611,400.00	2,760,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	863,300.00	1,464,300.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,103,400.00	800,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	756,600.00	3,097,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	204,200.00	5,750,000.00
210604	Урсгал засвар	-	5,750,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	941,000.00	3,360,000.00
210702	Дотоод албан томилолт	941,000.00	3,360,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,611,100.00	2,713,940.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,611,100.00	1,430,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		474,440.00

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210807	Газрын төлбөр		163,500.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	30,734,000.00	161,804,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,734,000.00	161,076,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	727,500.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>500,121.00</b>	<b>9,657,240.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	1,465,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	1,465,000.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	680,360.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		680,360.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	121.00	7,511,880.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	121.00	7,511,880.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,680,000.00</b>	<b>10,550,000.00</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,680,000.00</b>	<b>10,550,000.00</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,680,000.00</b>	<b>10,550,000.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	14,680,000.00	10,550,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,680,000.00	10,550,000.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(14,680,000.00)</b>	<b>(10,550,000.00)</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,266,577,802.00	164,384,566.80	-393,546,367.99	2,037,416,000.81
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,266,577,802.00	164,384,566.80	-393,546,367.99	2,037,416,000.81
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,266,577,802.00	164,384,566.80	-393,546,367.99	2,037,416,000.81
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,266,577,802.00	164,384,566.80	-393,546,367.99	2,037,416,000.81
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,266,577,802.00	164,384,566.80	-393,546,367.99	2,037,416,000.81
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	18,645,000.00			18,645,000.00
D08	Тайлант үеийн үр дүн			-75,362,082.17	-75,362,082.17
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,285,222,802.00	164,384,566.80	-468,908,450.16	1,980,698,918.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

БӨА-2023/13/НА-СТА-ТШЗ

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	697,874,000.00	696,430,760.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	697,874,000.00	696,430,760.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	696,409,000.00	694,965,760.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	242,662,000.00	242,662,000.00
<b>210101</b>	Үндсэн цалин	176,127,700.00	175,239,432.00
<b>210102</b>	Нэмэгдэл	32,900,000.00	32,900,000.00
<b>210103</b>	Унаа хоолны хөнгөлөлт	18,900,000.00	19,605,000.00
<b>210104</b>	Урамшуулал	14,734,300.00	14,917,568.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	29,953,300.00	29,953,300.00
<b>210201</b>	Тэтгэврийн даатгал	20,436,100.00	20,436,100.00
<b>210202</b>	Тэтгэмжийн даатгал	2,379,300.00	2,379,300.00
<b>210203</b>	ҮОМШӨ-ний даатгал	1,903,500.00	1,903,500.00
<b>210204</b>	Ажилгүйдлийн даатгал	475,800.00	475,800.00
<b>210205</b>	Эрүүл мэндийн даатгал	4,758,600.00	4,758,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	276,059,300.00	275,296,420.00
<b>210301</b>	Гэрэл, цахилгаан	6,083,200.00	5,836,744.00
<b>210302</b>	Түлш, халаалт	262,976,100.00	262,976,100.00
<b>210303</b>	Цэвэр, бохир ус	7,000,000.00	6,483,576.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,594,100.00	9,331,800.00
<b>210401</b>	Бичиг хэрэг	1,372,800.00	1,210,500.00
<b>210402</b>	Тээвэр, шатахуун	2,860,000.00	2,760,000.00
<b>210403</b>	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,464,300.00	1,464,300.00
<b>210405</b>	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	572,000.00	800,000.00
<b>210406</b>	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,325,000.00	3,097,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,000,000.00	3,000,000.00
<b>210604</b>	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,360,000.00	3,360,000.00
<b>210702</b>	Дотоод албан томилолт	3,360,000.00	3,360,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,831,000.00	2,713,940.00
<b>210801</b>	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,430,000.00	1,430,000.00
<b>210802</b>	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00
<b>210803</b>	Даатгалын үйлчилгээ	190,000.00	159,000.00
<b>210804</b>	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	71,000.00
<b>210805</b>	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00
<b>210806</b>	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	474,440.00
<b>210807</b>	Газрын төлбөр	200,000.00	163,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	128,949,300.00	128,648,300.00
<b>210901</b>	Бараа үйлчилгээний бусад зардал	127,019,300.00	126,718,300.00

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,930,000.00	1,930,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,465,000.00	1,465,000.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,465,000.00	1,465,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,465,000.00	1,465,000.00
13	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	697,874,000.00	697,874,000.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	402,573,700.00	402,573,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	402,573,700.00	402,573,700.00
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	295,300,300.00	295,300,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	295,300,300.00	295,300,300.00
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	30.00	30.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>30.00</b>	<b>30.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	24.00	24.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>24,794,000.00</b>	<b>71,115,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>24,794,000.00</b>	<b>56,806,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	24,794,000.00	56,806,000.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	-	15,750,000.00
210101	Үндсэн цалин		11,224,655.00
210102	Нэмэгдэл		2,038,025.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		1,955,000.00
210104	Урамшуулал		532,320.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	-	2,250,000.00
210201	Тэтгэврийн даатгал		2,250,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,880,000.00	3,500,000.00
210604	Урсгал засвар		3,500,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,674,000.00	35,306,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,674,000.00	35,306,000.00
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>6,749,000.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		6,749,000.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>7,560,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	-	7,560,000.00

225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		7,560,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	24,794,000.00	71,205,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	24,794,000.00	71,205,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,000,000.00	52,506,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,594,000.00	800,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	200,000.00	17,899,000.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Биеийн тамир,спортын газар нь спортын төрлүүдийг жигд өндөр түвшинд хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий байгууллага.

Тус газар нь 2022 онд Спортын төрлүүдийг жигд өндөр түвшинд хөгжүүлж, орон нутгийн тамирчдын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хүн амын хэрэгцээнд нийцүүлэн биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар бие бялдрын боловсролтой, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийн хүртээмжийг бүрдүүлэн санал санаачилга гаргах
- Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх
- Төрийн болон төрийн бус байгууллагын, уялдаа холбоог сайжруулах
- Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлэх
- Орон нутгийн тамирчдыг дэмжиж Улс, бүсийн түвшинд өрсөлдөх чадвар амжилтыг нэмэгдүүлэх
- Үндэсний уламжлалт спортыг орон нутагт хөгжүүлэх, төрийн бодлогыг дэмжиж, тэмцээн, наадмыг жил бүр зохион байгуулна.
- Спортын сургалт дасгалжуулалт, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчин, дасгалжуулагчдын ёс зүйн хариуцлагыг сайжруулах
- Байгууллагын төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах
- Биеийн тамир, спортын салбарын бодлого, үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, дүн шинжилгээ хийж, сайжруулах

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

#### ***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Биеийн тамир, спортын газар нь Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого болон Биеийн тамир спортын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр улсын төсвөөс санхүүжиж, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын лсын хороонд санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Биеийн тамир, спортын газар 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### ***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Биеийн тамир, спортын газрын захирлын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/08 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

БӨА-2023/13/НА-СТА-ТШЗ

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53.0 сая төгрөгөөр буюу 2.53 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	819.8	819.8
Бараа материал	61.401.2	55.677.4	-5.723.8
Үндсэн хөрөнгө	2.031.651.1	1.983.594.3	-48.056.8
Нийт хөрөнгө	2.093.052.3	2.040.091.5	-52.960.8
Өр төлбөр	55.636.3	59.392.6	3.756.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2.037.416.0	1.980.698.9	-56.717.0
<u>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</u>	<b>2.093.052.3</b>	<b>2.040.091.5</b>	<b>-52.960.8</b>

Авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Авлагын данс 819.8 мянган төгрөгөөр өссөн, бараа материалын дансны үлдэгдэл 5.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 48.0 сая төгрөгөөр буурсан нь 29.2 сая төгрөгийн хөрөнгийг нэмж орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 77.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 735.9 сая, орон нутгийн төсвөөс 295.3 сая, нийт зарлагыг 1.031.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 333.4 сая төгрөгөөр бууруулж 697.9 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 402.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 295.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 402.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 295.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 696.4 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 0.8 сая төгрөгөөр, бусад зардлыг 0.6 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	275,036.90	274,657.54	379.36	99.86%
2	Нийтлэг үйлчилгээ	295,300.30	294,537.42	762.88	99.74%
3	Биеийн тамирын уралдаан тэмцээн	81,867.80	81,722.80	145.00	95.50%
4	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	1,465.00	1,465.00	-	100.00%
5	Нийтийн Биеийн тамир	44,204.00	44,048.00	156.00	99.65%
6	<b>ДҮН</b>	<b>697,874.00</b>	<b>696,430.76</b>	<b>1,443.24</b>	<b>99.79%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Биеийн тамир, спортын газар 2022 онд 64,4 сая төгрөгийн нэмэлт төсөв авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Биеийн тамир, спортын газар 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Биеийн тамир, спортын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 578.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0% байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Биеийн тамир, спортын газарт завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 3.1 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	3.100.0	1	3.100.0	100%
Зөвлөмж					100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>3.100.0</b>	<b>1</b>	<b>3.100.0</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 18.6 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Байгууллагын эзэмшилд газрыг бүртгэхдээ санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор буруу бүртгэж тайлагнасан 18.6 сая төгрөгийг хасаж, Засгийн газрын оруулсан капитал дансанд нэмэгдүүлж залруулсан.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

#### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрээс төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй	1	18.645.0			1	18.645.0	1	18.645.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>18.645.0</b>			<b>1</b>	<b>18.645.0</b>	<b>1</b>	<b>18.645.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								